

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ИХ СУРГУУЛИУДЫН СУРАЛЦАГЧДЫН “EMOTIONAL QUOTIENT (EQ)” ШИНЖИХ СУДАЛГАА

Д.Хишигжаргал¹, Л.Мөнхчулуун¹, Ш.Оюунчимээ
¹АШУҮИС, Дархан-Уул аймаг дахь АУС
khishigjargal.d@mnums.edu.mn

Abstract

The human mind is a combination of more than 120 interrelated abilities. Multiple Intelligence identifies four types of quotient: IQ (Intelligence Quotient), EQ (Emotional Quotient), CQ (Creative Quotient), and AQ (Adversity Quotient). Salovey and Mayer coined the term “emotional intelligence” in 1990, describing it as a: “Form of social intelligence that involves the ability to monitor one’s own and others’ feelings and emotions, to discriminate among them, and to use this information to guide one’s thinking and action.” Through Psychologist and journalist Daniel Goleman’s book “Emotional Intelligence” was published in 1995 Emotional Intelligence has been attracted by the world.

Goleman defines it as “the ability to identify, assess and control one’s own emotions, the emotion of others and that of groups.” Goleman developed a performance-based model of EQ to assess employee levels of emotional intelligence, as well as to identify areas of improvement. Daniel Golman believes that it is not necessary to take separate classes to develop EQ, but that it is effective to practice EQ skills in all classes. Market society has come to value all aspects of human development, especially the art of communication. The EQ, also known as the social intelligence, demonstrates a complex ability to understand one’s own and others’ emotions, to express one’s emotions appropriately, to be self-motivated, to be patient, and to always be optimistic. A person with a high EQ is able to control his emotions, adapt to his environment and work successfully. EQ is an important factor to train skilled professionals in any sector.

Key word: Intellectual abilities, emotions, social relations

Түлхүүр үг: Оюун ухааны чадамж, сэтгэл хөдлөл, нийгмийн харилцаа,

Үндэслэл:

Хүний оюун ухаан харилцан хамаарал бүхий 120 гаруй чадварын нэгдэл байдаг ба IQ (Intelligence Quotient) оюун ухаан, EQ (Emotional Quotient) сэтгэл хөдлөлөө удирдах, CQ (Creative Quotient) аливаад бүтээлч хандах, AQ (Adversity Quotient) бэрхшээлийг даван туулах гэх зэрэг нь Multiple Intelligence буюу олон талт оюун ухаан юм.

1990 онд Питер Саловей, Жон Мейер нар сэтгэл хөдлөлөө удирдах чадамж /EQ/ хэмээх нэршлийг анх гаргаж, сэтгэл судлаач, сэтгүүлч Даниэл Гоулмэны “Emotional Intelligence” ном

1995 онд хэвлэгдсэнээр EQ-ийн талаар дэлхий нийтээрээ анхаарах суурь тавигдсан байна.

Даниэл Гоулмэний EQ-г “өөрийнхөө болон бусдын ашигтай үйл ажиллагааг бие махбодиор биш сэтгэлтэй нь харьцан зохицуулах, удирдах мөн хүмүүсийг идэвхижүүлдэг, тэднийг чин сэтгэлээсээ ойлгодог чадвар юм” гэжээ.

Гэхдээ Даниэл Гоулмэн EQ-г хөгжүүлэхийн тулд заавал тусад нь хичээл орох шаардлагагүй, харин бүх хичээлдээ EQ чадварыг хөгжүүлэх агуулгыг шингээх, үргэлж дадлагажуулах нь үр дүнтэй гэж үзсэн байна.

Зах зээлийн нийгэм нь хүний бүх талын хөгжил, ялангуяа харилцааны урлагийг ихээхэн үнэлдэг болсон. Нийгмийн харилцааны оюун ухаан гэгддэг EQ нь өөрийн болон бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, сэтгэл хөдлөлөө зохистой илэрхийлэх, өөрийгөө урамшуулах, тэвчээртэй байх, үргэлж сэтгэл өөдрөг явах зэрэг цогц чадварыг харуулдаг. EQ өндөртэй хүн өөрийнхөө сэтгэлийн дотоод хөдлөлд автахгүй, биеэ барих чадвар эзэмшсэн байх бөгөөд орчинтойгоо дасан зохицож, ажлаа амжилттай явуулж байдаг.

Аль ч салбарт чадварлаг мэргэжилтэнг бэлтгэхэд EQ шинж давамгайлсан байх нь бас нэг чухал хүчин зүйл юм.

Зорилго: Дархан-Уул аймаг дахь их сургуулиудын оюутнуудын EQ үзүүлэлтийг шинжих

Зорилт:

АУС, ХААИС, ТИС сургуулиудын оюутнуудаас EQ шинжийн судалгаа авах

Тус судалгааны үр дүнд үнэлгээ, шинжилгээ хийх

Материал арга зүй:

Судалгаанд нийт 300 оюутан хамрагдсан. Үүнд: Дархан-Уул аймаг дахь АУС-ийн 100 оюутан, ХААИС-ийн 100 оюутан, ТИС-ийн 100 оюутанг санамсаргүй түүврийн аргаар сонгов. Даниэл Гоулмэний EQ-ын 5 чадвараар, Bar On-ны EQ-ын стандарт онооны үнэлгээгээр үнэлэв. Судалгааны ажлын үр дүнг Microsoft office - 2016, статистик боловсруулалтыг SPSS - 20.0 програмыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Судалгааны хэсэг:

Даниэл Гоулмэний хувьд EQ-г дараах таван чадварт хуваажээ. Энэ нь,

1. Өөрийгөө танин мэдэх (Self-awareness)
2. Өөрийгөө удирдах чадвар (Selfcontrol)
3. Өөрийгөө идэвхжүүлэх чадвар (Motivation)
4. Бусдыг ойлгох чадвар (Empathy)
5. Бусадтай харилцах чадвар (Handle relationship) юм.

Энэ таван чадвараар EQ-г шинжих судалгааг сорил өгөлгүйгээр шинжих нь амаргүй. Гэхдээ дараах зарим шинж байвал EQ үзүүлэлт өндөр гэж үздэг байна.

Хүснэгт 1

№	Шинжүүд	Нийт	Дархан-Уул аймаг дахь их сургууль		
			Анагаах ухааны сургууль	Хөдөө аж ахуйн их сургууль	Технологийн их сургууль
1	Бусдыг ойлгох байдал				
	1. Ойлгохыг хичээдэг	259(77.6)	78(68.4)	88(80.0)	93(84.5)
	2. Бусдын байр суурьнаас харах	72(21.4)	35(30.7)	22(20.0)	15(13.6)
	3. Огт үгүй	3(1.0)	1(0.9)	0(0.0)	2(1.8)
2	Үгүй гэж хэлж чаддаг уу?				
	1.Тийм	117(35.1)	32(28.1)	40(36.4)	45(40.9)
	2. Үгүй	106(31.3)	80(70.2)	19(17.3)	7(6.4)
	3. Заримдаа	111(33.6)	2(1.8)	51(46.4)	58(52.7)
3	Өөрийхөө давуу болон сул талаа мэддэг эсэх				
	1 Мэддэг	197(57.7)	70(61.8)	59(53.6)	68(61.8)
	2 Сайн мэдэхгүй	135(40.5)	44(38.6)	51(46.4)	40(36.4)
	3 Мэддэгүй	2(1.8)	0(0.0)	0(0.0)	2(1.8)
4	Хариу хүлээдэггүй бусдад тусалдаг эсэх				
	1. Чаддаг	199(59.6)	90(78.9)	60(54.5)	49(44.5)
	2. Чаддаггүй	60(17.9)	22(19.3)	22(20.0)	16(14.5)
	3. Заримдаа	75(22.5)	2(1.8)	28(25.5)	45(40.9)
5	Сайн унтаж амардаг эсэх				
	1. Тийм	174(52.0)	71(62.3)	59(53.7)	44(40.0)
	2. Үгүй	81(24.0)	43(37.7)	15(13.6)	23(20.9)
	3. Заримдаа	79(36.0)	0(0.0)	36(32.7)	43(39.1)
6	Бүхнийг төгс байлгах гэж хичээдэг үү?				
	1. Тийм	158(47.0)	84(74.2)	28(25.5)	46(41.8)
	2. Үгүй	62(18.6)	18(15.8)	25(22.7)	19(17.3)
	3. Заримдаа	114(34.4)	12(10.5)	57(51.8)	45(40.9)
7	Байгаа зүйлдээ талархаж чаддаг уу?				
	1.Үргэлж	177(53.2)	38(33.3)	52(47.3)	87(79.1)
	2. Хааяа	140(41.6)	73(64.0)	48(43.6)	19(17.3)
	3. Бага зэрэг	17(5.2)	3(2.6)	10(9.1)	4(3.6)
8	Бусдын сэтгэлээс үл хамааран сэтгэл хангалуун байж чаддаг				
	1. Тийм	198(59.4)	59(51.8)	57(51.8)	82(74.5)
	2. Заримдаа	125(37.3)	54(47.4)	51(46.4)	20(18.2)
	3. Бага зэрэг	11(3.3)	1(0.9)	2(1.8)	8(7.3)

Бусдыг ойлгох байдал нь 77,6% ойлгохыг хичээдэг, 21,4% бусдын байр сууринд өөрийгөө тавьж үзэх, 1,0% бусдыг ойлгохыг хүсдэггүй. Үгүй гэж хэлж чаддаг уу? гэдэгт 35,1% тийм, 31,3% үгүй, 33,6% заримдаа чаддаггүй. Өөрийн давуу болон сул талаа мэддэг эсэхэд 57,7% мэддэг, 40,5% сайн мэдэхгүй, 1,8% сайн мэдэхгүй гэсэн байна. Хариу хүлээлгүй тусалж чаддаг эсэхэд 59,6% чаддаг, 17,9% чаддаггүй, 22,5% заримдаа тусалдаг байна. Сайн унтаж амардаг эсэхэд

52,0% тийм, 24,0% сайн унтаж амардаггүй, 36,0% заримдаа гэж хариулсан байна.

Бүхнийг төгс байлгах гэж хичээдэг үү? 47,0% тийм, 18,6% үгүй, 34,4% заримдаа. Байгаа зүйлдээ талархаж чаддаг уу? 53,2% үргэлж, 41,6% хааяа, 5,2% бага зэрэг талархдаг байна. Бусдын сэтгэгдлээс үл хамааран сэтгэл хангалуун байж чаддаг уу? 59,4% тийм, 37,3% заримдаа, 3,3% бага зэрэг сэтгэл хангалуун гэж үзсэн байна.

Хүснэгт 2 . EQ шинжийн үнэлгээ

Шинжүүд	Үнэлгээ		
	Сайн n (%)	Дунд n (%)	Муу n (%)
Бусдыг ойлгох байдал	259(77,6)	72(21.4)	3(1.0)
Үгүй гэж хэлж чаддаг уу?	117(35.1)	116(31.3)	111(33.6)
Өөрийхөө давуу болон сул талаа мэддэг эсэх	197(57.7)	135(40.5)	2(1.8)
Хүнд тусалж чаддаг эсэх	199(59.6)	60(17.9)	75(22.5)
Сайн унтаж амардаг эсэх	174(52.0)	81(24.0)	79(36.0)
Бүхнийг төгс байлгах гэж хичээдэг үү?	158(47.0)	62(18.6)	114(34.4)
Байгаа зүйлдээ талархаж чаддаг уу?	177(53.2)	140(41.6)	17(5.2)
Бусдын сэтгэгдлээс үл хамааран сэтгэл хангалуун байж чаддаг уу?	196(59.4)	125(37.3)	11(3.3)

Судалгаанд хамрагдсан 77.6% буюу 259 оюутан бусдыг ойлгох чадвар сайн, 59.6% буюу 199 оюутан хариу хүлээлгүй тусалж чаддаг, 57.7% буюу 197 оюутан өөрийн давуу талаа мэддэг байгаа нь EQ шинж давамгайлсан байна.

Үр дүн

Энэхүү судалгаанд хамрагдсан нийт оюутны 77,6% нь бусдыг ойлгохыг хичээдэг, өөрийхөө давуу ба сул талаа 57,7% мэддэг, 59,6% нь хүнд тусалж чаддаг, 47,0% нь бүхнийг төгс байлгахыг хичээдэг EQ шинж давамгайлж байгаа нь харагдаж байна.

Оюутнуудын 31,3% үгүй гэж хэлж чаддаггүй, 33,6% нь заримдаа үгүй гэж хэлж чаддаггүй байгаа нь анхаарал татаж байна.

Үр дүнгээс үзэхэд оюутнуудын өөртөө итгэлтэй, өөрийгөө танин мэдэх (Self-awareness), өөрийгөө удирдах (Self control) шинжүүдийг хөгжүүлэх хэрэгтэй нь энэ судалгаанаас харагдаж байна.